**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/132 Мандалговь

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,
төсөл, арга хэмжээг төлөвлөх, эрэмбэлэх ажлыг
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.3, 60.1.8, 66-р зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Н.Эрдэнэ-Очир | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |
| Гишүүд: | Г.Энхтайван | (Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ) |
| | Э.Чагнаадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга) |
| | О.Мөнхзул | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | С.Ариунжаргал | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | С.Бат-Оргил | (Сайнцагаан сумын Засаг дарга) |
| | Ж.Шинэ-Уянга | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга) |
| | Б.Нямтуяа | (Байгаль орчин аялал жуулчлалын газрын орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур |

4822100316

| | | |
|---|---|---|
| | | амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн) |
| | Б.Энхтүвшин | (Тогтвортой амьжиргаа-3 төслийн ажилтан) |
| Нарийн бичгийн дарга: | Ж.Уянга | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн) |

2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтын төслийг бэлтгэж иргэд, олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан тэдний эрх ашигт нийцсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, холбогдох журмын шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ